



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН НЭР: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХИЙМЭЛ ОЮУНД СУУРИЛСАН
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /УЛААНБААТАР,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ/ - ИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД
ХИЙХ ДОТООД АУДИТ**

АУДИТ ХИЙСЭН ХЭЛТЭС:

ХУУЛЬ ЗҮЙ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АУДИТ ХИЙГДСЭН ХЭЛТЭС:

САНХҮҮ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АУДИТЫН ТӨРӨЛ: САНХҮҮГИЙН ДОТООД АУДИТ

АУДИТЫН ХУГАЦАА : 2026.04.24 – 2026.05.08

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ

2.3 Аудитын арга, аргачлал

3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА, ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

3.1 Байгууллага, нэгжийн сайн туршлага

3.2 Засаглалын удирдлагын талаар

3.3 Эрсдэлийн удирдлагын талаар

3.4 Дотоод хяналтын талаар

4. АУДИТЫН ҮР ДҮН

4.1 Илэрсэн асуудлууд

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

НЭГ.ТАНИЛЦУУЛГА

Улсын бүртгэлийн ерөнхий газрын эрхэм зорилго нь улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэхэд орших бөгөөд Монгол Улсын төр, засгаас улсын бүртгэлийн чиглэлээр баримтлах бодлогыг хэрэгжүүлж, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд, олон нийтэд чанартай, шуурхай хүргэх, оюуны өмчийн эрхийн хамгаалалт, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус газар хуульд заасны дагуу дараах чиг, үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах;
- Бүх шатны бүртгэлийн байгууллага, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн цаасан болон цахим архив, цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, хадгалах, хамгаалалтын найдвартай байдлыг хангах;
- Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн байгууллагатай хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, тэдгээрийн харьяа байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх;
- Салбарын хэмжээний мэргэжлийн боловсон хүчний чадавх, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;
- Улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах;
- Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаарх мэдээ, тайланг нэгтгэх, мэдээлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, үйл ажиллагаанд хэрэглэх баримт бичгийн загвар, маягт, холбогдох заавар, журмыг хуульд заасны дагуу баталж мөрдүүлэх;
- Улсын бүртгэлийн аргачлал, арга зүйг олон улсын ангилал, стандартын жишигт нийцүүлэн боловсруулж, эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр гаргаж мөрдүүлэх.

Тус байгууллагын Санхүү үйлчилгээний хэлтэс нь төсвийг оновчтой хуваарилах, санхүүжүүлэх, бүртгэх, хяналт тавих, тайлагнах, баталгаажуулах үйл ажиллагааг хууль, эрх зүйн хүрээнд зохион байгуулах зорилготойгоор хэлтсийн дарга-1, төсөв, худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн-1, зохион байгуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн-1, ерөнхий нягтлан бодогч-1, нягтлан-4, нярав-2, жолооч-4, слесарь-1, цахилгаанчин-1 нийт 16 орон тоотойгоор чиг үүргийн дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХОЁР.АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас худалдан авах “Улсын бүртгэлийн хиймэл оюунд суурилсан мэдээлэл технологийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/” ажлыг гүйцэтгэх байгууллага сонгон шалгаруулах

үйл ажиллагаа нь холбогдох хууль, журам, зааврын дагуу хийгдэж байгаа эсэхэд санхүүгийн дотоод аудит хийж, үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

Дотоод аудитыг гүйцэтгэхдээ Улсын салбарын дотоод аудитын аргачлал, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт, заавруудыг баримталж Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтууд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/179 дугаар тушаалын 2 хавсралт, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал болон бусад холбогдох хууль, журмын дагуу үйл ажиллагааг хамруулна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын урсгал төсвийн санхүүжилтээр худалдан авах үйл ажиллагааг дотоод аудитад хамруулаагүй.

2.3 Аудитын арга, аргачлал:

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав. Аудитын эдгээр горимын үр дүнд дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглуулж аудитын дүгнэлтээ гаргасан болно.

ГУРАВ.БАЙГУУЛЛАГА, НЭГЖИЙН САЙН ТУРШЛАГА, ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

3.1 Байгууллага, нэгжийн сайн туршлага:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журмыг баримтлан төлөвлөгөөт хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан;
- Батлагдсан төсөв 5,568,700.0 мянган төгрөг, гэрээний дүн 5,128,800.0 мянган төгрөг болсон ба нийт 439,900.0 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

3.2 Засаглалын талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 161 дүгээр тогтоолоор Д.Давааням Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар томилогдон ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/61 дүгээр “Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай” тушаалаар 17 хүний бүрэлдэхүүнтэй даргын зөвлөл томилогдон ажиллаж байна.

3.3 Эрсдэлийн удирдлагын талаар:

Эрсдэлийн удирдлагын бодлого, журмыг Хууль зүй, дотоод хэргийн яамны нэгдсэн арга аргачлалын хүрээнд зохион байгуулдаг ба Улсын бүртгэлийн байгууллагын 2026 оны үйл ажиллагааны эрсдэлийн төлөвлөгөөг батлан мөрдөж ажиллаж байна.

Нэгжийн эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлэхэд хүлээн зөвшөөрөх эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн талаар нэгдсэн ойлголт чиг хандлага, эрсдэлийн мэдээллийг ашиглах зэрэг үнэлэх шалгууруудын түвшин бүрд байгууллагын эрсдэлийн удирдлагыг тодорхойлж, үнэлсэн байна.

3.4 Дотоод хяналтын системийн талаар:

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан журмын дагуу дотоод хяналт шалгалтыг үйл ажиллагааны чиглэл бүрээр хэрэгжүүлж ажиллаж байна.

ДӨРӨВ.АУДИТЫН ҮР ДҮН

Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтууд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/179 дугаар тушаалын 2 хавсралт, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026 оны А/39 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулан худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж ажилласан эсэхийг дүгнэсэн.

Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/104 дүгээр тушаалын хавсралтаар баталсан тендер шалгаруулалтын баримт бичгийн дагуу УБЕГ/20260102008/01/01 дугаартай “Улсын бүртгэлийн хиймэл оюунд суурилсан мэдээлэл технологийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ худалдан авах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын баримт бичиг”-ийг боловсруулж, батлуулжээ.

Нээлттэй тендер шалгаруулалтыг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 09 цаг 30 минутад нээхэд “Грандмакс” ХХК болон “Интерактив” ХХК нар тендерийн материал ирүүлсэн ба “Интерактив” ХХК 5,358,457.8 мянган төгрөгөөр, “Грандмакс” ХХК 5,128,800.0 мянган төгрөгөөр тус тус үнийн саналыг ирүүлсэн байна.

Бараа худалдан авах, тендер шалгаруулах баримт бичгийн дагуу “Грандмакс” ХХК –ийн ирүүлсэн тендерийн баримт шаардлага хангасан тул сонгогдож 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр 2026/23, 2026/38 дугаартай гурван талын гэрээг Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, “Грандмакс” ХХК -тай байгуулан хамтран ажиллаж байна.

Гэрээ байгуулах эрх олгосон асуудлаар гомдол, маргаан гараагүй ба худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил, эрсдэл илрээгүй байна.

ТАВ.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас худалдан авах төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсан “Улсын бүртгэлийн хиймэл оюунд суурилсан мэдээлэл технологийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/” худалдан авах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдаж, хэмнэлттэй, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмыг хангасан байна.